



**БОГД БАНК**  
ХУВЬЦААТ КОМПАНИ

БОГД БАНКНЫ ТОС-ЫН АЖЛЫН ХЭСЭГ

2024

1-Р УЛИРЛЫН ТАЙЛАН

[www.bogdbank.com](http://www.bogdbank.com)



## ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО

Богд Банк нь байгаль орчинд ээлтэй, нийгмийн хариуцлагаа ухамсарласан, ил тод үйл ажиллагаа явуулахыг эрхэмлэдэг билээ. Бид өөрсдийн санхүүжүүлэх төсөлд ч энэхүү шалгуурыг тавьж, дэмжин ажилладаг бөгөөд уг зорилгын хүрээнд Монгол Улсын Тогтвортой санхүүжилтийн (ТоС) хөтөлбөрт нэгдэн орж, 2015 оноос ТоС хөтөлбөрийн албан ёсны гишүүнээр элсэн орсон. Түүнээс хойш Богд банк өдөр тутмын үйл ажиллагаа болон бүтээгдэхүүн үйлчилгээндээ тогтвортой хөгжлийн зорилтуудыг үргэлж тусгаж ирсэн.



## ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

Богд Банк нь тайлант хугацаанд НОГООН зээлийг санхүүжүүлэх болон жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан хөнгөлөлттэй зээл олгох зорилгоор гадаадын Triple jump/Dutch Good Growth хөрөнгө оруулалтын сангаас амжилттайгаар Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд зориулан анхны санхүүжилтийг амжилттай татсан билээ.

Бид Тогтвортой санхүүжилтийн хүрээнд 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдөр “Монголын Ногоон санхүүгийн корпораци”, “Жерес олон улсын төрийн бус байгууллага”-тай хамтран “Дулаан шийдэл II” төслийг нэвтрүүлэхээр зээлийн бүтээгдэхүүнийг зорилтот харилцагчдад хүргэх санамж бичигт тус тус гарын үсэг зурж баталгаажууллаа. Хамтын ажиллагааны хүрээнд дулаалгын бүтээгдэхүүнийг санхүүжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэххүлэмжийн хийн ялгарлыг бууруулах чиглэлээр уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд хувь нэмэр оруулах юм.



## ҮЛГЭРЛЭН МАНЛАЙЛАЛ

Богд банк нь Монголын “Тогтвортой санхүүжилтийн холбоо”-той хамтран ажилладаг ба уг хөтөлбөрт 2015 оноос эхлэн үндсэн гишүүнээр элсэн орсон цагаас өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээ болон өдөр тутмын үйл ажиллагаандаа тогтвортой хөгжлийн зорилтуудыг тусгаж, сайжруулсаар ирсэн. Тогтвортой байдал нь зөвхөн гадагшаа чиглэсэн бус дотогшоо чиглэсэн буюу Богд банкны ажиллагсдаа чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Бид нийт ажиллагсдынхаа эрүүл мэндэд анхааран “Иргэн бүрд Эрүүл мэнд уриан дор” ажлын байран дахь хоол зүйн зохистой хэрэглээ, эрүүл амьдралын зөв дадал гэсэн сургалтад нийт ажиллагсдаа хамруулан дотогшоо чиглэсэн алхмыг хэрэгжүүлж эхлээд байна.



## НӨӨЦИЙН ХЭМНЭЛТ

Бид нөөцийн хэмнэлтийн хүрээнд жил бүр шинэ санаа санаачилгыг гарган ажиллахыг зорин ажилладаг бөгөөд, цаасны хэрэглээ, хог хаягдлыг бууруулах Аюултай хог хаягдал дахин боловсруулах үйлдвэртэй хамтран ажиллахаар боллоо. Цаасны хэмнэлтийн хүрээнд Банк дотроо ажилтнуудын чөлөөний хуудсыг цахим бүртгэл рүү шилжүүлэх ажлыг хэрэгжүүлсэн. Мөн бид залуусын нэгдэл болох TsoilogsoZ залуустай хамтран “Өнгө нэмье” байгууллагаас “Хог хаягдлын менежмент”-ийн сургалтыг авсан.

Цаг бүртгэл - Чөлөө

Түрэг: 1

Имя: [input type="text"]

Галар нэвтрэл: [input type="text"]

Адрес: [input type="text"]

Чөлөөний төрөл: [input type="text"]

Чөлөөний өдөр: [input type="text"]

Ажлын үйлдвэр: [input type="text"]

Огноо: 2024-04-08

Тайлбар: [input type="text"]



Банк нь олон нийтэд зориулсан өөрийн сүлжээгээр “Байгаль орчноо хайрлан хамгаалах”, “Усны хэмнэлт”-тэй холбоотой уриалга мэдээллийг тухай бүр хүргэн ажиллаж байна.